

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 27.060.10

Ахуйн хэрэглээний зуух. Техникийн ерөнхий шаардлага	MNS 5216-1 : 2011
Householder stove. General technical requirements	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 04 дүгээр сарын 28-ний өдрийн 20 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

Энэ стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

1 Зорилго

Энэхүү стандартын зорилго нь Монгол гэр болон түүнтэй адилтгах сууцанд ашиглах халаалт болон гал тогооны зориулалттай хатуу түлшээр ажилладаг зууханд тавих техникийн ерөнхий шаардлагыг тогтооход оршино.

2 Хамрах хүрээ

Энэ стандарт нь 3 кВт –аас 7 кВт хүртэл чадалтай зуухыг үйлдвэрлэх, импортлоход хамаарна.

3 Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах иш татсан стандарт, баримт бичгийг хэрэглэсэн. Он заасан ишлэлийн хувьд зөвхөн иш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй ишлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

3.1 MNS 5458:2005, Халаалтын ба гэрийн зуухны яндангаар гарах утааны найрлага дах агаар бохирдуулагч бодисын хүлцэх дээд хэмжээ ба хэмжих арга;

3.2 MNS 5568:2005, Шингэн түлшээр ажилладаг ахуйн хэрэглээний зуух. Техникийн ерөнхий шаардлага;

3.3 BS EN 13240:2001, Хатуу түлшээр ажилладаг гэрийн зуух. Техникийн ерөнхий шаардлага ба шалгах арга.

4 Нэр, томъёо тодорхойлолт

4.1

гэрийн зуух

хатуу түлшийг шатааж гаргасан дулаанаар Монгол гэр болон түүнтэй адилтгах сууцанд ашиглах халаалт болон гал тогооны зориулалттай төхөөрөмж;

4.2

ашигт үйлийн коэффициент

нэг килограмм хатуу түлшийг шатаахад ялгарсан дулааны хэдэн хувийг ашигтай зарцуулж байгааг илэрхийлэх коэффициент;

MNS 5216-1 : 2011

4.3

халаах гадаргуу

түлшнээс ялгарах дулааныг гэрийн доторх агаарт дамжуулах гадаргуу;

4.4

гэрийн доторх агаарын температур

зуухны төвөөс 1,5 метр тойрогт, шалнаас 40 см зайд хэмжсэн агаарын дундаж температур;

4.5

яндангийн таталт

утаа болон хүйтэн агаарын нягтын зөрүүгээр галын хотолд үүсгэх сийрэгжилт;

4.6

утааны температур

гэрийн тооноор яндан гарах цэгт хэмжсэн утааны температур;

4.7

тоосонцорын ялгарал

зуухны яндангаар ялгарах тоосонцорын хэмжээ;

4.8

угаарын хийн ялгарал

зуухны яндангаар ялгарах угаарын хийн хэмжээ.

5 Техникийн шаардлага

5.1 Зуухны техникийн шаардлагыг 1-р хүснэгтэд үзүүлэв.

Зуухны техникийн шаардлага

1-р хүснэгт

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоон утга /хүлцэх хэмжээ/	Тайлбар
1	Чадал	кВт	3-7	
2	АҮК	%-иар, багагүй	70	
3	Утааны таталт /галын хотлын сийрэгжилт/	Па	6-12	
4	Утааны температур	°С, дундаж температур	200	Хэвийн ажиллагааны үед

5.2 Байгаль орчинд нөлөөлөх байдал буюу экологийн үзүүлэлтэд тавих шаардлагыг 2-р хүснэгтэд үзүүлэв.

Зуухны экологийн үзүүлэлт

2-р хүснэгт

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоон утга /хүлцэх хэмжээ/	Тайлбар
-----	----------	-------------	------------------------------	---------

1	Зуухны яндангаар гарах тоосонцорын хэмжээ (PM 2,5)	мг/МДж	200	
		г/кг	3	
2	Зуухны яндангаар гарах угаарын хий буюу нүүрсхүчлийн дутуу исэл (CO)	г/МДж	10	
3	Зуухны яндангаар гарах Азотын исэл (NO _x)	мг/МДж	-	
4	Зуухны яндангаар гарах хүхрийн исэл болон хүхэрт нэгдэл (SO _x , H ₂ S)	г/кг, дээшгүй	2	

5.3 Зуухны галын хотол, хүхээгийг үнс, хөөнөөс хялбар цэвэрлэх боломжтой байхаар зуухыг зохион бүтээсэн байна.

5.4 Зуух нь технологийн зурагтай байна.

6 Аюулгүй ажиллагааны шаардлага, баталгаа

6.1 Зуухан дахь түлшний шаталтаас үүсэх температур халах гадаргууд 140 °C-аас багагүй, 400 °C-аас ихгүй байна.

6.2 Зуухны үнсний тосгуур нь тал бүрээсээ битүүмжлэгдсэн байх ба нүүрэн талдаа нээлхийтэй байна. Зуухны ам, агаар сорох нүхээр улайссан түлшний хэсэг буюу үнс гадагш унахаас зуухыг бүрэн хамгаалж зохион бүтээсэн байна.

6.3 Үйлдвэрлэгч нь бүтээгдэхүүнээ энэхүү стандартад тэнцсэн гэдгээ хэрэглэгч (захиалагч)-д нотолж, лабораторийн шинжилгээний дүн, эсвэл түүнийг үндэслэн өөрийн шийдвэрээр олгосон чанарын баталгаа, холбогдох журмын дагуу авсан тохирлын гэрчилгээ болон бусад баримт бичгийг хэсэг бүрт дагалдуулж болно.

6.4 Аливаа хэрэглэгч буюу захиалагч зуухыг турших, шалгах, чанарын баталгаажуулалт шаардах, үнэлэх, үнэн зөв мэдээлэл, лавлагаа авах зэргийг харилцан тохиролцож хэрэгжүүлнэ.

7 Турших арга

7.1 Зуухыг MNS 5216-2¹ стандартын дагуу туршина.

7.2 Технологийн шийдэл, зуухны загварт өөрчлөлт оруулах, боловсронгуй болгох, шинэ загварын зуухыг үйлдвэрлэлд бэлтгэх зорилгоор загварын туршилтыг хийнэ. Загварт оруулсан өөрчлөлт нь энэ стандартын ямар шаардлагыг хамарч байгаагаас хамааруулан загварын туршилт хийх чиглэлийг сонгоно.

7.3 Туршилтад хамруулах зуухны тоо, хийсэн өөрчлөлтөөс хамааран өөр өөр байж болно. Загварын туршилтыг зуухны технологийн процесс, заавар, хийцэд өөрчлөлт оруулан үнэлэх замаар хийж гүйцэтгэнэ. Зуух нь энэ оруулсан өөрчлөлтийг тэсвэрлэх ёстой. Туршсан зуухны тоог оруулсан өөрчлөлтийн тооцоотой хамт тодорхойлно.

¹MNS 5216-2 стандарт боловсруулалтын шатанд байгаа болно.

MNS 5216-1 : 2011

7.4 Баталгаажуулалтын туршилтыг хүлээн авах туршилтад орсон гурваас цөөнгүй зууханд хийж гүйцэтгэнэ.

8 Туршилтын үр дүнг илэрхийлэх

8.1 Хүлээн авах – хүлээлгэн өгөх, ээлжит болон загварын туршилтын үр дүнг дараах мэдээлэл агуулсан протокол үйлдэж албан ёсны болгоно.

- a) Зуухыг үйлдвэрлэгч;
- b) Зуухны үйлдвэрийн дугаар;
- c) Зуухны холбогдох баримт бичиг;
- d) Туршилт явуулсан түлшний төрөл;
- e) Туршилтын нөхцөл ба арга;
- f) Энэ стандартын тэмдэглэгээ ба нормчилсон үзүүлэлт;
- g) Туршилтын үр дүн;
- h) Дүгнэлт;
- i) Туршилт хийсэн огноо;
- j) Туршилт хийсэн хүний нэр, гарын үсэг.

9 Хаяглах

9.1 Зуух тус бүрд шошго хэрэглэх бөгөөд түүнд дараах зүйлийг бичнэ. Үүнд:

- Үйлдвэрлэгчийн нэр, оршин байгаа газрын нэр;
- Үйлдвэрлэсэн огноо;
- Зуухны марк;
- Ашиглах заавар (ямар түлш хэрэглэх тухай болон аюулгүйн нөхцөл);
- Энэхүү стандартын тэмдэглэгээ мөн Үндэсний тохирлын тэмдэг (дүрс) хэрэглэх эрх авсан бол шошго дээр ашиглах;
- Баталгаат хугацаа;

ТӨГСӨВ.